

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолын 2.4 дэх заалтыг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-нд хавсралтад дурдсан эмийг нэмсүгэй.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /С.Энхболд/-т даалгасугай. Үүнд:

3.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад нэмэлтээр оруулсан эмийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх;

3.2.Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ бүхий эмийн сангуудад эмийн жагсаалтыг хүргэх, мэдээлэх, сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулах;

3.3.Тогтоолд орсон нэмэлт өөрчлөлтийг цахим системд оруулах.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Ц.Сарантуяа)-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

